# 2022 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Save the Children



Save the Children

2022 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

# ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2022

# ХҮҮХДИЙГ ИВЭЭХ САНГИЙН ТАНИЛЦУУЛГА

**1919**
ИХ БРИТАНИД БАЙГУУЛАГДСАН

**120**
УЛС ОРОНД ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛДАГ

**1994**
МОНГОЛ УЛСАД ҮЙЛ АЖИЛЛАГААГАА ЭХЛҮҮЛСЭН

Хүүхдийг Ивээх Сан бол 1919 онд байгуулагдсан, хүүхдийн төлөөх үйлсээрээ дэлхийд тэргүүлэгчдийн нэг бөгөөд шашин, улс төрөөс ангид олон улсын бие даасан байгууллага юм. Хүүхдийг Ивээх Сан нь нийгэм, улс төрийн нөхцөл байдлын өөрчлөлт, онцгой байдлын үеэс урт хугацааны хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх үйл явцад хүүхдийг хамгаалж, хүүхдийн эрхийг цогцоор нь хангахыг дэмжин ажиллаж ирсэн.

Бид хүүхдийг хамгаалж, эсэн мэнд амьдрах, хөгжих эрхийг хангахын төлөө тэмцэж, хүүхдийг өөрт байгаа боломж бололцоогоо бүрэн дүүрэн ашиглахад нь тусалдаг. Хүүхдийг Ивээх Сан нь хүүхдийг сонсож, тэдний оролцуулж, хүүхдийн амьдралд чухал нөлөө үзүүлэх аливаа шийдвэр гаргахдаа тэдний үзэл бодолд зохих ач холбогдол өгдөг хариуцлагатай нийгмийг цогцлоохын төлөө ажилладаг.

Хүүхдийг Ивээх Сан өнгөрсөн 100 гаруй жилийн хугацаанд өргөжин тэлж, өнөөдөр дэлхийн 120 гаруй улсад үйл ажиллагаа явуулж байна. 1994 онд нээгдсэн Хүүхдийг Ивээх Сангийн Монгол Улс дахь хөтөлбөр 1994-2009 онд Их Баританийн Хүүхдийг Ивээх Сангийн, 2009 оноос Японы Хүүхдийг Ивээх Сангийн удирдлага дор хүүхдийн амьдралд урт хугацааны, тогтвортой, эерэг өөрчлөлтийг бий болгох зарчмыг баримтлан, тулгамдаж буй асуудлуудад бодитой, системтэй шийдлийг олох аргазүйг эрхэмлэн ажиллаж байна.

## АЛСЫН ХАРАА:

Хүүхэд бүр эсэн мэнд амьдрах, хамгаалуулах, хөгжих, оролцох эрхээ эдэлдэг ертөнцийг бий болгох

## ЭРХЭМ ЗОРИЛГО:

Бодит дэвшил гаргах замаар хүүхдийн амьдралд эерэг нөлөө үзүүлж, тэдний амьдралд урт хугацааны өөрчлөлт авчрах

## ҮНДСЭН ЧИГЛЭЛҮҮД:

- Боловсрол
- Хүүхэд хамгаалал
- Хүүхдийн эрхийн засаглал
- Хүүхдийн ядуурлыг бууруулах
- Эрүүл мэнд
- Хүмүүнлэгийн яаралтай тусламж

## ХҮҮХДИЙГ ИВЭЭХ САНГИЙН МОНГОЛ УЛСАД ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БУЙ ОРОН НУТАГ




## ДАРААХ ГУРВАН ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД БОДИТ ДЭВШИЛ ГАРГАХАД ЧИГЛЭН АЖИЛЛАЖ БАЙНА:

### ЭСЭН МЭНД АМЬДРАХ

Урьдчилан сэргийлж болох шалтгаанаар 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийг таслан зогсоono

### СУРАХ

Бүх хүүхэд чанартай суурь боловсрол эзэмшиж чаддаг болсон байна

### ХАМГААЛУУЛАХ

Хүүхдийн эсрэг хүчирхийллийг нийгмээрээ үл тэвчдэг болсон байна






# МЭНДЧИЛГЭЭ

Та бүхний амрыг айлтгая.
Улиран одсон 2022 он Хүүхдийг Ивээх Сангийн хувьд амжилт ололтоор дүүрэн, бүтээлч жил байлаа. Бид төлөвлөсөн төсөл, хөтөлбөрүүдээ амжилттай хэрэгжүүлж, Монголын хүүхэд, залуустболовсрол, хүүхэд хамгаалал, хүүхдийн эрхийн засаглал, эрүүл мэнд, хүүхдийн ядуурлыг бууруулах, хүмүүнлэгийн хөтөлбөрүүдээрээ дамжуулан бодит дэмжлэг үзүүлэн, тэдний сайн сайхны төлөө бодит дэвшил, өөрчлөлт гаргаж чадлаа.

Хүүхдийг Ивээх Сан 2022 онд хүүхэд хамгааллыг бэхжүүлэх, ардчиллын боловсрол олгох, ил тод байдал, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр тодорхой төслүүдээ амжилттай хэрэгжүүлж дуусгалаа. Үүний зэрэгцээ охидын эрхийг хамгаалах, орон нутгийн өсвөр үеийн хүүхэд, залуучуудын бизнес ур чадвар, энтрепренершип боловсролыг дэмжих, хүүхэд бүрийг боловсролд тэгш хамруулах зэрэг төслүүдээ амжилттайгаар үргэлжлүүлэн хэрэгжүүлсэн юм. Мөн тэгш боломжийг бүрдүүлэх замаар суралцахуйг дэмжих, Улаанбаатар хотын гэр хороололд хүртээмжтэй, таатай орчин бүрдүүлэхэд залуусын оролцоог нэмэгдүүлэх болон эрүүл мэндийн төсөл шинээр хэрэгжүүлэв.

Эдгээр төслүүдээс онцлон дурдвал, Хүүхдийг Ивээх Сан АНУ-ын Олон улсын хөгжлийн агентлагийн санхүүжилтээр “Монгол Улсад КОВИД-19 цар тахлын эсрэг хариу арга хэмжээг сайжруулахад техникийн туслалцаа үзүүлэх, зорилтод нийцүүлэн тархварзүйн хяналтыг дэмжих нь” төслийг АНУ-ын FHI 360 байгууллагатай хамтран хэрэгжүүллээ. Энэхүү төсөл Монгол орны бүх аймаг, сум, нийслэл хотыг хамарч, 21 аймгийн 330 сумын 660 гаруй эмч, эмнэлгийн ажилтнуудыг сургалтад хамрууллаа. Мөн 330 суманд 800 хүчилтөрөгчийн баллоныг дагалдах хэрэгслийн хамт хүлээлгэн өгч, 21 аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлгүүд, төв болон төрөлжсөн нарийн мэргэжлийн эмнэлгүүдийн 45 инженерийг сургалтад хамрууллаа. Бид Монгол хүн бүрийн эрхэм баялаг болсон эрүүл мэндийн төлөө төсөл хэрэгжүүлсэндээ сэтгэл хангалуун байгаа юм. 2022 онд манай төсөл, хөтөлбөрүүдийн үр шимийг 41,310 хүүхэд, 58,580 эцэг, эх, багш, ажилтнууд зэрэг хүмүүс шууд хүртсэн байна.

Хүүхдийг Ивээх Сангаас 2022 онд хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөрүүд болон тэдгээрийн үр дүнг энэхүү тайландаа дэлгэрэнгүй тусгалаа. Энэ дашрамд бидэнтэй хамтран ажиллаж, дэмжин, Монголын ирээдүй болсон хүүхэд, залуусын төлөө үнэтэй хувь нэмэр оруулсан санхүүжүүлэгч байгууллагууд, эцэг эхчүүд, хүүхдүүд, хамтран ажилласан бүх талуудад Хүүхдийг Ивээх Сангийн бүх ажилтны нэрийн өмнөөс гүн талархлаа илэрхийлж байна.

Л.Баян-Алтай
Хүүхдийг Ивээх Сангийн Монгол дахь
хөтөлбөрийн менежер/Суурин төлөөлөгч

# 2022 ОНД БИД

Хүүхдийг ивээх сан 2022 онд монголын

**41,310**

хүүхдэд дэмжлэг үзүүллээ



Насанд хүрсэн

**17,270**

хүн манай төсөл, хөтөлбөрүүдийн үр шимийг хүртжээ



Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй, бичиг үсгийн боловсролгүй

**60**

малчин эцэг эх уншиж, бичиж, тоолж сурлаа



2022 онд бид нийт

**58,580**

хүнд шууд хүрч ажиллалаа

2022 онд бид давхацсан тоогоор нийт

**2 САЯ**

орчим хүнд шууд бусаар хүрч ажиллалаа

**6,099**

хүүхдийн анги дэвших, суралцах үйл явцад дэмжлэг үзүүлэв



# 2022 ОНД БИД



16 хамтарсан багийн
**123**
гишүүдийг чадавхжуулав

Улаанбаатар хот болон 21 аймгийн 330 сумын
**660**
гаруй эмч, эмнэлгийн ажилтнуудыг чадавхжууллаа




Биднийг цахим орчинд
**80,000**
хүн идэвхтэй дагажээ

Говь-Алтай аймгийн чандмань суманд шүдний кабинет байгуулагдаад хоёр сарын хугацаанд нийт
**437**
иргэнд тусламж үйлчилгээ үзүүллээ



2022 оны нийт төсөв (ам.доллар)
**2,556,891**



# БОЛОВСРОЛЫН ХӨТӨЛБӨР

*Бид 2022 онд хүүхэд болон насанд хүрэгчдийн суралцахуйг дэмжих, боловсролын хүртээмжийг нэмэгдүүлэх, сургалтын орчныг сайжруулах, тэгш хамруулах боловсрол, үл ялгаварлах хандлага ойлголтыг түгээх чиглэлээр хэд хэдэн төслийг амжилттай хэрэгжүүллээ. Үүнд:*



"Хүүхэд бүрийг боловсролд тэгш хамруулах зарчмыг дэмжих нь - 2" төслөөс тэгш хамруулах боловсролын сургалтын гурван модуль, нэг гарын авлагыг шинэчлэн боловсруулж, сургагч багшийн болон сургуульд түшиглэсэн сургалтуудыг зохион байгууллаа.Сургагч багшийн сургалтад зорилтот 16 дунд сургуулийн 156 багш, сургуулийн удирдах ажилтнууд, сургуулийн үндсэн сургалтад 865 багш хамрагдаж тэгш хамруулах боловсролын сургалтын арга зүй, тусгай хэрэгцээтэй хүүхдийг дэмжих хөтөлбөрийн арга зүйд суралцлаа.

Монгол Улсад боловсролын чанар, хүртээмжийг сайжруулах зорилгоор "Тэгш боломжийг бүрдүүлэх замаар суралцахуйг дэмжих" шинэ төслийг Боловсрол, шинжлэх ухааны яам хэрэгжүүлж эхэллээ. Хүүхдийг Ивээх Сан төслийн санхүүжилтийг зохицуулагч байгууллагаар ажиллаж байна. 2022-2025 онд гурван жилийн хугацаатай хэрэгжих уг төсөл нь боловсролын салбарын тэргүүлэх гурван чиглэл болох "Тэгш хамруулан сургах боловсрол", "Сургуулийн хоолны үйлдвэрлэл, үйлчилгээ" болон "Хосолсон сургалт"-ыг хөгжүүлэх зорилготой.



Хүүхдийг Ивээх Сан хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдтэй малчин эцэг эхчүүдэд туслах зорилгоор "Боловсролын тусгай хэрэгцээтэй хүүхдүүдийн малчин эцэг, эхчүүдийн бичиг үсгийн боловсролыг сайжруулах нь" төсөл хэрэгжүүлэв. Энэхүү санаачилгын хүрээнд Өвөрхангай аймгийн тусгай хэрэгцээтэй хүүхдүүдтэй 60 эцэг эх бичиг үсгийн чадварын сургалтад хамрагдаж, өөрсдийн хүүхдүүдээ цаашид сургах, туслах чадвараа сайжруулав. Энэхүү төслийн үр дүнг бусад орон нутагт түгээх зорилгоор "Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй малчин эцэг эхчүүдийн бичиг үсгийн боловсролыг дээшлүүлэх замаар хүүхдийнхээ сурч хөгжих болон сайн сайхан байдлыг дэмжих чадавхыг сайжруулах нь" төслийг Өвөрхангай, Ховд аймагт хэрэгжүүлж эхэллээ.

Тусгай хэрэгцээтэй хүүхдийн хөгжлийг үе тэнгийн хүүхдүүдийн оролцоонд тулгуурлан дэмжих зорилготой "Хамтдаа суралцъя" бичил төслийг нийслэл болон 3 аймгийн 8 сургууль, цэцэрлэгт хэрэгжүүлж байна.

## “ХҮҮХЭД БҮРИЙГ БОЛОВСРОЛД ТЭГШ ХАМРУУЛАХ ЗАРЧМЫГ ДЭМЖИХ НЬ-2” ТӨСӨЛ

Тэгш хамруулах боловсролын сургалтын гурван модуль, нэг гарын авлагыг шинэчлэн боловсруулж, сургагч багшийн болон сургуулийн үндсэн сургалтуудыг зохион байгууллаа. Сургагч багшийн сургалтад Улаанбаатар, Ховд, Өвөрхангай аймгийн зорилтот 16 ерөнхий боловсролын сургуулийн 156 багш, удирдах ажилтнууд, үндсэн сургалтад бага, дунд ангийн 865 багш хамрагдаж тэгш хамруулах боловсролын сургалтын арга зүй, тусгай хэрэгцээтэй хүүхдийг дэмжих хөтөлбөрийн арга зүйд суралцлаа.

> “Зорилтот сургуулиудын нийт 1,724 эцэг эх сургалтад хамрагдаж, хүүхдийнхээ сурах үйл явцыг дэмжих арга зүй, оролцоо, нөлөөллийн арга барилд суралцлаа.”







## ГОЛ ҮР ДҮН

Төслийн хоёр дахь жилийн зорилтот сургуулиудын гараан нөхцөл байдлыг тодорхойлох суурь судалгааг хийж, үр дүнг төслийн хамтрагч талуудад танилцууллаа.

Тусгай хэрэгцээтэй хүүхдийг боловсролын үйлчилгээнд хамруулах, тэдний сурах, хөгжих эрхийг хангах зорилгоор тэгш хамруулах боловсролын бодлогын уулзалтуудыг оролцогч талуудтай хамтарч тогтмол зохион байгуулж ажиллалаа. Үүний үр дүнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ:

- Тусгай хэрэгцээтэй хүүхдийн талаарх статистик мэдээлэл цуглуулах загвар хуудас, судалгааны асуумжийг төслийн хүрээнд шинэчлэн боловсруулж Боловсролын удирдлага мэдээллийн системд байршууллаа. Эдгээр нь ердийн сургуульд суралцаж буй тусгай хэрэгцээтэй сурагчдын талаарх статистик мэдээллийн чанарыг сайжруулах, багш нар ангидаа суралцаж байгаа хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн талаарх мэдээллийг цуглуулахад туслах зорилготой юм.
- Танхимын сургалтад тогтмол хамрагдах боломжгүй хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсролын үйлчилгээнд хамруулах тухай заалтыг “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд хөгжлийн цогц дэмжлэг үзүүлэх аргачлал”-д тусгаж Боловсрол, шинжлэх ухаан, Эрүүл мэнд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны хамтарсан шийдвэрээр баталгаажуулсан.
- Бүх шатны сургалтын байгууллагад хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн онцлогт тохирох хэрэглэгдэхүүн, сургалтын орчныг бүрдүүлэх журмын шинэчилсэн төслийг боловсрууллаа.

## СУРГАЛТЫН МОДУЛИУД

Ерөнхий боловсролын сургуулийн бага, дунд ангийн багш нарын тэгш хамруулах боловсролын онол, арга зүйн мэдлэг, ойлголтыг гүнзгийрүүлэх, хүүхдийн ялгаатай хэрэгцээнд нийцсэн арга зүй эзэмшүүлэх, мөн эцэг эх, олон нийтэд тэгш хамруулах боловсролын талаарх зерэг ойлголтыг өгч, хандлагад нь нөлөөлөх зорилго бүхий сургалтын модулиудыг шинэчлэн боловсруулж хэвлүүллээ. Үүнд:

**210**

Тэгш хамруулах боловсрол - “5 дугаар ангийн сурагчдыг бага ангиас дунд ангид дэвшин суралцахад дэмжлэг үзүүлэх арга зүй” сургалтын модулийн сургалтад зорилтот сургуулийн 201 бага ангийн багш хамрагдаж, тэгш хамруулах боловсролын мэдлэг, арга зүйгээ сайжруулллаа.

**225**

Тэгш хамруулах боловсрол - “Хамтдаа дэвшин суралцъя” сургалтын гарын авлагын сургалтыг нийт 225 сурагчдын зөвлөлийн гишүүдийг хамруулан зохион байгуулж, хүүхэд үе тэнгийнхний дунд тэгш хамруулах боловсролыг дэмжих нөлөөллийн ажлуудыг зохион байгууллаа.

**759**

Тэгш хамруулах боловсрол - “ЕБС-ийн дунд ангийн багш нарт зориулсан мэргэжил дээшлүүлэх сургалтын модуль”-ийн сургалтад зорилтот сургуулийн дунд ангийн 759 багш хамрагдлаа.

**1,724**

Тэгш хамруулах боловсрол- “Хүүхдийн сурах үйл явцад эцэг эхчүүдийн оролцоог нэмэгдүүлэх арга зүй” сургалтын модулийн сургалтад 915 багш хамрагдлаа. Мөн зорилтот сургуулиудын нийт 1,724 эцэг эхчүүд сургалтад хамрагдаж, хүүхдийнхээ сурах үйл явцыг дэмжих арга зүй, оролцоо, нөлөөллийн арга барилд суралцлаа.

**215**

Тусгай хэрэгцээтэй хүүхдийн хөгжлийг дэмжих зорилгоор зорилтот 8 дунд сургуульд Хүүхэд хөгжлийн танхимыг байгууллаа. Эдгээр төвүүдээр дамжуулан нийт бага, дунд ангийн 215 тусгай хэрэгцээтэй сурагчдад хөгжлийн дэмжлэг, ганцаарчилсан сургалтын үйлчилгээ үзүүллээ.

**7**

Тусгай хэрэгцээтэй хүүхдэд зориулсан сургуулийн дэд бүтцийг сайжруулах засварын ажлыг төслийн зорилтот 7 сургуульд хийж, тэдгээр хүүхдүүдийн хэрэгцээнд нийцсэн ариун цэврийн өрөө, налуу зам зэргийг ашиглалтад оруулллаа.

**3,3 сая**

Тэгш хамруулах боловсролын талаарх олон нийтийн ойлголт, дэмжлэгийг нэмэгдүүлэх зорилготой “Хамтдаа суралцъя” сошиал медиа нөлөөллийн аяныг зохион байгууллаа. Энэхүү аяны хүрээнд 4 видео бүтээл, 3 постер, 19 нийтлэл, ярилцлагыг бэлтгэж уламжлалт болон сошиал хэвлэл мэдээллийн орчинд нийтлүүлсэн байна. Үүний үр дүнд 3,3 сая хэрэглэгчдэд мэдээллээ хүргэж, нөлөөлөл сурталчилгаа хийлээ.





“Хүүхэд ар гэрийнхээ амьжиргааны байдал, биеийн хөгжил тэргүүтэй олон шалтгааны улмаас хичээлийн хөтөлбөрөөс хоцордог. Анги бүрт суралцахуйн бэрхшээлтэй хүүхэд бий. Гэвч энэ нь хөгжлийн бэрхшээлээс ялгаатай ойлголт юм. Өмнө нь суралцахуйн бэрхшээлтэй хүүхдүүдийг сурах хүсэлгүй, эсвэл зүгээр л тааруу сурдаг гэж боддог байсан бол энэхүү төсөл хэрэгжсэнээр тэдэнтэй тулж ажиллаж, нөхцөл байдлыг өөр өнцгөөс олж харах боломжтой болсон.”

Чингэлтэй дүүргийн 37-р дунд сургуулийн сургалтын менежер Ш.Амарзаяа




О.Дашням, 11 настай, “Хүүхэд бүрийг боловсролд тэгш хамруулах зарчмыг дэмжих нь” төсөлд хамрагдсан Ерөнхий боловсролын сургуулийн суралцахуйн бэрхшээлтэй сурагч. Тэрээр хуучин сургуульдаа явах тийм ч дуртай байгаагүй. Харин одоо сурч буй сургуульдаа явах их дуртай. Хэдийгээр хичээлийн шинэ жил эхлээд удаагүй ч найзтай болж, түүнтэйгээ нээлттэй ярилцдаг болсон.

## “ТЭГШ БОЛОМЖИЙГ БҮРДҮҮЛЭХ ЗАМААР СУРАЛЦАХУЙГ ДЭМЖИХ” ТӨСӨЛ

Монгол Улсад боловсролын чанар, хүртээмжийг сайжруулах зорилгоор “Тэгш боломжийг бүрдүүлэх замаар суралцахуйг дэмжих” шинэ хөтөлбөрийг Боловсрол, шинжлэх ухааны яам хэрэгжүүлж эхэллээ. Уг хөтөлбөрийн оролцогч талуудын зохицуулагчаар Монгол Улс дахь Японы Элчин сайдын яам,

> “Боловсролын дэлхийн түншлэл” (GPE) байгууллагаас боловсролын салбарын хөгжлийн дунд хугацааны төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд дэмжлэг болгон 5.0 сая ам.долларын буцалтгүй тусламжийг үзүүлэх болсон.

харин буцалтгүй тусламжийн санхүүжилтийг зохицуулагч байгууллагаар Хүүхдийг Ивээх Сан ажиллаж байна.

Төсөл нь боловсролын салбарын гурван тэргүүлэх чиглэл болох "Тэгш хамруулан сургах боловсрол", "Сургуулийн хоолны үйлдвэрлэл, үйлчилгээ" болон "Хосолсон сургалт"-ыг хөгжүүлэхэд чиглэгдэх бөгөөд хөтөлбөрийн хэрэгжилтийг дээрх чиглэлүүдээр боловсролын салбарт хөрөнгө оруулж буй Японы Олон улсын хамтын ажиллагааны байгууллага (ЖАЙКА), БНСУ-ын Олон улсын хамтын ажиллагааны байгууллага (КОЙКА), Хүүхдийг Ивээх Сан болон хөгжлийн бусад түншүүд дэмжин ажиллаж байна.







2022 онд “Тэгш боломжийг бүрдүүлэх замаар суралцахуйг дэмжих” төслийн хүрээнд дараах ажлыг хийж гүйцэтгэв. Үүнд:

- Төслийн санхүүжилтийн гэрээнд холбогдох талууд 8 дугаар сард гарын үсэг зурснаар төсөл хүчин төгөлдөр болж, 10 дугаар сард нээлтийн арга хэмжээг БШУЯ-ны ёслолын танхимд зохион байгуулав.
- Төсөл хэрэгжүүлэх нэгжийг байгуулж, төслийн зохицуулагч, санхүү, худалдан авалт, хяналт-шинжилгээ үнэлгээний ажилтан гэсэн 4 хүний орон тоотой ажиллаж байна.
- Төслийн удирдах хороог 11 хүний бүрэлдэхүүнтэй байгуулж, ээлжит хоёр удаагийн хурлыг зохион байгуулж, 2023 оны төлөвлөгөөг баталлаа.
- Төслийн “Тэгш хамруулах боловсрол” бүрэлдэхүүн хэсгийн зорилтот 18 сургуулийг, “Сургуулийн үдийн хоол хөтөлбөр” бүрэлдэхүүн хэсгийн зорилтот 45 сургуулийг шалгуур үзүүлэлтийн дагуу сонгож БШУ-ны Сайдын тушаалаар баталгаажуулав.

> Шинжлэх ухаан, Технологийн Их сургуультай хамтран бакалаврын зэрэгтэй хоол зүйч бэлтгэх хөврүүлэх сургалтын хөтөлбөрийг боловсруулан, уг хөтөлбөрт хамрагдахаар өргөдөл гаргасан 60 хүнээс 22 оюутныг сонгон шалгаруулж, нийт 130 сая орчим төгрөгийн тэтгэлэг олгов.

## БОЛОВСРОЛЫН ХӨТӨЛБӨР

Манай оронд 1990-ээд оны зах зээлийн шилжилтийн үеэр олон хүүхэд сургууль завсардан, хөдөлмөр эрхэлж, зарим нь мал дээр гарч аав ээждээ туслах болсноор тэдний хувьд зарим сөрөг үр дагавар гарсан. Үүний нэг жишээ нь эдгээр хүүхдүүд өнөөдөр өөрсдөө эцэг, эх болж үр хүүхдүүдээ өсгөх, эрдэм боловсролд нь анхаарахад олон бэрхшээл тулгарч байгаа юм. Наад зах нь бичиг үсгийн боловсрол тааруугаас хүүхдийнхээ хичээл номыг хийлгэх, хөгжил




боловсролд туслахад хүндрэл гарч байна. Ялангуяа хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй бол эцэг, эхийн зүгээс илүү дэмжлэг үзүүлэх шаардлагатай байдаг. Тиймээс Хүүхдийг Ивээх Сан “Боловсролын тусгай хэрэгцээтэй хүүхдүүдийн малчин эцэг, эхчүүдийн бичиг үсгийн боловсролыг сайжруулах нь” төслийг Австралийн Сайн дурын хөтөлбөрийн Нөлөөллийн сангийн санхүүжилтээр хэрэгжүүллээ. Энэхүү төсөл нь зайн болон явуулын сургалтаар дамжуулан хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй, бичиг үсэггүй малчин эцэг, эхчүүдийн унших, бичих, тоо бодох чадварыг дээшлүүлэхээс гадна хүүхэдтэйгээ ажиллах арга барилыг сайжруулах, цаашлаад төслийн үр дүнг бусад орон нутагт түгээн дэлгэрүүлэх зорилготой байсан юм.

> Есөн сар үргэлжилсэн энэхүү төсөлд Өвөрхангай аймгийн Арвайхээр, Хархорин, Уянга сумын боловсролын тусгай хэрэгцээт хүүхэдтэй 60 эцэг эх хамрагдаж, унших, бодох, тоо бодох үндсэн чадваруудыг эзэмшсэн юм.






### ГОЛ ҮР ДҮН

- Сургалтын эцсийн үнэлгээгээр төсөлд хамрагдсан эцэг эхчүүдийн унших чадвар 12.1 хувиар, бичих чадвар 11.2 хувиар, тооцоолох чадвар нь 13.5 хувиар тус тус ахисан.
- Бага ангид хүүхэд нь сурдаг малчин эцэг эхчүүд өөрсдөө бичиг үсгийн чадвараа сайжруулснаар гэр бүлийн орчинд хүүхдээ сурч хөгжихөд нь дэмжлэг үзүүлэх боломж бүрдсэн.
- Эцэг эхчүүдийн хувьд нэг анги болж хамт олонтой болсноор шинэ найз нөхөдтэй болох, бие биеэсээ харилцан суралцах боломж бүрдээд зогсохгүй, өөртөө итгэх итгэлтэй болж хамтач сэтгэлгээ болон хариуцлагатай байхад суралцлаа.
- Зорилтот эцэг эхчүүд өөрсдийнхөө үзэл бодлоо илэрхийлэх, бусдыг сонсох, бусдыг хүндлэх зэрэг үр чадваруудыг эзэмшсэн.



> Би хүүхдээ хараад гэртээ байдаг. Сумын төв хааяа ордог ч мөнгө сайн тоолж сураагүй, гарын үсгээ зурж чаддаггүйгээсээ болж банк, дэлгүүрт ордоггүй. Төсөлд хамрагдаад нөхөртэйгөө хамт сураад явж байна. Одоо бичиг үсэг сураад, хүүгээ эмчлүүлээд, сургуульд явуулж, хүүдээ үсэг зааж өгнө гэж бодохоор өөртөө нэг л итгэж өгөхгүй, гоё байгаа.

**Өвөрхангай аймгийн малчин Н.Дуламсүрэн**

# “БОЛОВСРОЛЫН ТУСГАЙ ХЭРЭГЦЭЭТЭЙ ХҮҮХДҮҮДИЙН МАЛЧИН ЭЦЭГ, ЭХЧҮҮДИЙН БИЧИГ ҮСГИЙН БОЛОВСРОЛЫГ САЙЖРУУЛАХ НЬ” ТӨСӨЛ

Төслийн үр дүнг бусад орон нутагт түгээх зорилгоор “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй малчин эцэг эхчүүдийн бичиг үсгийн боловсролыг дээшлүүлэх замаар хүүхдийнхээ сурч хөгжих болон сайн сайхан байдлыг дэмжих чадавхыг сайжруулах нь” төслийг Өвөрхангай, Ховд аймагт хэрэгжүүлж эхэллээ. Аймгуудын Насан туршийн Боловсролын төв болон зорилтот дөрвөн сумдын Насан туршийн боловсролын нэгжийн багш нартай хамтран уг төслийг хамтран хэрэгжүүлж байна.

Энэхүү төслөөр хөдөө орон нутаг дахь хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй малчин эцэг эх, асран хамгаалагчдын бичиг үсгийн түвшинг тогтоож, хүүхдийнхээ боловсрол, сайн сайхан байдлыг дэмжихэд нь тохиолдож буй саад бэрхшээлийг тодорхойлж, улмаар хэрэгцээнд нь суурилсан сургалтын хөтөлбөр боловсруулан зайн болон танхимын, явуулын сургалтуудаар дамжуулан мэдлэг, ур чадварыг нь дээшлүүлэх юм.

## ГОЛ ҮР ДҮН

**16**

Насан туршийн боловсролын төвийн багш нарт зориулсан сургалтын хөтөлбөрийг боловсруулж, зорилтот орон нутгийн 16 багшийг хамруулсан сургалтыг цахимаар зохион байгуулав.

**190**

Сургалтад хамрагдсан багш нар хосолсон сургалтын арга зүйгээр малчин өрхүүдэд дараагийн шатны 190 цагийн сургалтыг хүргэв.

**60**

Нийт 60 гаруй малчин эцэг эх, асран хамгаалагчийг сонгож, сургалтын 60 багц бэлтгэн тараав. Мөн зорилтот 4 сумын Насан туршийн боловсролын нэгжийн багш нарт нийт 14,156,000 төгрөгийн үнэ бүхий зөөврийн компьютер, гурван үйлдэлт принтер, интернэт модем, DVD/VCD тоглуулагч, зөөврийн чанга яригч зэрэг тоног төхөөрөмжийг нийлүүлэв.



# ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ХӨТӨЛБӨР

Бид Хүүхэд хамгааллын хөтөлбөрийн хүрээнд Монгол Улсад Хүүхэд хамгааллын тогтолцоог бэхжүүлж, үүрэг хүлээгчдийг чадавхжуулах чиглэлээр 2022 онд идэвхтэй бөгөөд амжилттай ажиллалаа. Бид кейс менежментийн чанарын үнэлгээг хийж, хамтарсан багуудыг сурган, сэтгэцийн гэмтэлд суурилсан хохирогч, даван туулагчид ээлтэй үйлчилгээ үзүүлэх арга зүйг мэргэжилтнүүдэд танилцуулж, хүмүүжлийн эерэг аргыг түгээхийн зэрэгцээ, хүүхэд хамгааллын судалгаануудыг хийж гүйцэтгэлээ.

НҮБ-ын Итгэлцлийн сангийн санхүүжилттэй **“Охидыг хүчирхийлэл, мөлжлөгөөс хамгаалах нь”** төслийг Улаанбаатар хотын нийгэм, эдийн засгийн түвшин доогуур 5 дүүргийн 12-18 насны охидыг КОВИД-19 цар тахлын хүчин зүйлийн улмаас хүндэрсэн хүчирхийлэл, мөлжлөгт өртөх эрсдэлээс эрүүл мэнд, хүүхэд хамгаалал, боловсролын үйлчилгээгээр дамжуулан хамгаалах зорилгын хүрээнд хэрэгжүүлж байна.

Японы Олон Улсын Хамтын ажиллагааны агентлагийн (ЖАЙКА)-гийн санхүүжилттэй **“Монгол Улсад хүүхэд хамгааллын тогтолцоог бэхжүүлэх нь”** төслийн хоёрдугаар үе шатыг бүс, орон нутгийн түвшинд хүүхэд хамгааллын хамтарсан багийг чадавхжуулахад ажлын байранд зөвлөгөө өгөх, кейс хурал зохион байгуулах, кейс менежмент хийх чиглэлээр үргэлжлүүлэн хэрэгжүүлж дуусгалаа. Түүнчлэн эцэг эх, асран хамгаалагч, сурган хүмүүжүүлэгч нарт хүмүүжлийн эерэг аргын сургалтыг зохион байгуулж, Монгол Улсын Хүүхдийн эрхийн тухай болон Хүүхэд хамгааллын тухай хуулиудын хэрэгжилтийг дэмжин ажиллаж, хүчирхийлэл хэрэглэхгүйгээр хүүхдийн хүмүүжил, суралцахуйг чиглүүлэхийг сурталчлан ажиллалаа.



> Хүүхэд хамгааллын энэхүү хоёр төслийн хүрээнд “Охидыг хүчирхийлэл, мөлжлөгөөс хамгаалах нь” төслийн суурь судалгаа, Нөхцөл байдлын үнэлгээ, Түр хамгаалах байр, нэг цэгийн үйлчилгээний төвийн стандартыг үнэлэх судалгаа, “Монгол Улсад хүүхэд хамгааллын тогтолцоог бэхжүүлэх нь” төслийн эцсийн үнэлгээ, Кейс менежментийн чанарын үнэлгээ зэрэг нийт 5 судалгаа хийж, сургалтын нийт 16 модуль боловсруулж, 130 иргэний нийгмийн байгууллага, 150 төрийн, олон улсын болон бусад байгууллагуудтай хамтран ажиллаж бид шууд 14,000, шууд бусаар сая гаруй хүнд хүрч ажиллажээ.

## “ОХИДЫГ ХҮЧИРХИЙЛЭЛ, МӨЛЖЛӨГӨӨС ХАМГААЛАХ НЬ” ТӨСӨЛ

Нийт 9 дүүргийн Түр хамгаалах байр, Нэг цэгийн үйлчилгээний төвийн нийгмийн ажилтан, сэтгэл зүйчдийг урлагийн сэтгэл заслын төрөл бүрийн аргыг бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхдэд сэтгэл зүйн зөвлөгөө, заслын үйлчилгээ үзүүлэхдээ хэрхэн хэрэглэх талаар чадавхжуулах цуврал сургалтуудаа зохион байгууллаа. Сэтгэл зүйн зөвлөгөө заслын шинэлэг арга барилд суралцахаас гадна сургалтад хамрагдсан нийгмийн ажилтан, сэтгэл зүйчид бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгт өртсөн хохирогчтой ажиллахдаа сэтгэцийн гэмтэлд суурилсан, хохирогч төвтэй үйлчилгээ үзүүлэх талаар өөрсдийн мэдлэг, ур чадвараа нэмэгдүүлсэн.

> **“Охидыг хүчирхийлэл, мөлжлөгөөс хамгаалах нь” төсөл хохирогч/даван туулагчийг дахин гэмтэлд оруулахаас зайлсхийх, аюулгүй байдлыг нь нэмэгдүүлэх, хохирогчтой харилцах харилцааны үр дүнтэй, үр ашигтай байдлыг нэмэгдүүлэх зорилго бүхий сэтгэцийн гэмтэлд суурилсан, хохирогч төвтэй арга зүйг бодлого, журамд нэвтрүүлэх зорилготой юм.**



## “МОНГОЛ УЛСАД ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ТОГТОЛЦООГ БЭХЖҮҮЛЭХ НЬ” ТӨСӨЛ

Төслийн хүрээнд ЖАЙКА-гийн төслийн зорилтот 16 хүүхэд хамгааллын хамтарсан багийн гишүүдэд ажлын байран дээр нь зөвлөгөө өгөх нүүр тулсан уулзалт, онлайн уулзалт хийж, утсаар зөвлөгөө өгч ажиллалаа.

“Монгол Улсад хүүхэд хамгааллын тогтолцоог бэхжүүлэх нь” төсөл олон нийтийн хүүхэд хамгааллын мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх, орон нутгийн хамтарсан багийг чадавхжуулах замаар хүүхэд хамгааллын тогтолцоог бэхжүүлэх, Улаанбаатар хот болон зорилтот бүс нутгийн хүүхэд хамгааллын үйлчилгээг сайжруулах зорилготой.

Бид хүүхэд хамгааллын кейс менежментэд Хүүхдийг Ивээх Сангийн олон улсын шилдэг туршлагыг нэвтрүүлж, төрийн байгууллагуудыг идэвхжүүлэх үйл ажиллагаа, үйлчилгээг өргөжүүлж ажиллалаа. Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар (ГБХГЗГ)-тай хамтран “Кейс менежментийн чанарын үнэлгээ”-г үндэсний хэмжээнд зохион байгуулж хот, хөдөөгийн нийт 33 хүүхэд хамгааллын хамтарсан багийг оролцуулан олон улсад туршигдсан шинэ арга зүй, хэрэгслийг танилцууллаа. Үнэлгээний үр дүнд Монгол Улсад кейс менежментийн хэрэгжилтийг сайжруулах цогц төлөвлөгөө боловсруулж ажиллах зөвлөмж гарсныг ГБХЗХГ-тай хэлэлцэв.

Түүнчлэн, Улаанбаатар хот, Архангай, Дорнод аймагт эцэг эхчүүдэд зориулсан "Хүүхэд хүмүүжүүлэх зөерэг арга" (PDEP) сургалт зохион байгуулах чиглэлээр Канадын Манитоба их сургуультай хамтран ажилласаар байна.





> 56 хоног үргэлжилдэг Хүмүүжлийн зөерэг аргын сургалтыг 385 эцэг эхчүүдийг оролцуулан хийж, тэдний хүүхэдтэйгээ харилцах мэдлэг ур чадварыг нэмэгдүүлж, хандлагыг өөрчилж ажилласан.

> Энэ сургалтын гол онцлог нь эцэг, эхчүүд хүүхдээ хүмүүжүүлэхдээ хоорондын харилцаанд үүсдэг асуудлуудаа эерэг аргаар шийдэх гарц гаргалгаар олж авдаг. Эцэг, эхчүүдийг хүүхдийнх нь байр сууринд авч очиж, хүүхдэд юу болдог талаар өөрсдөөр нь мэдрүүлдэг онцлог арга зүйтэй сургалт.

Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын харьяа Сургалт, судалгаа мэдээллийн төвийн захирал, Хүмүүжлийн эерэг аргын хөтөлбөрийн чиглүүлэгч багш Г.Ариунчимэг






Хүүхдийг Ивээх Сангийн ажилтан Г.Ариунзаяа Дорнод аймагт хүүхдийн эрхийн нөхцөл байдлын тандалт судалгаа хийж байгаа нь.

## "АРДЧИЛЛЫН ТӨЛӨӨХ ШИНЭ ҮЕ" ТӨСӨЛ

НҮБ-ын Ардчиллыг дэмжих сангийн санхүүжилтээр сонгуульд залуучуудын оролцоо, мэдээлэлтэй санал өгөх боломжийг нэмэгдүүлэх зорилгоор залуучуудын дунд ардчиллын үнэт зүйлс, сонгуулийн үйл явцыг сурталчилж ажиллалаа. Уг төсөл нь сургуулийн сургалтын хөтөлбөрийг эргэн харж, хичээлээс гадуурх үйл ажиллагааг хөгжүүлэх замаар залуучуудын ардчиллын үнэт зүйлсийн талаарх ойлголт, хандлагыг сайжруулах зорилготой. Төслийн хүрээнд Улаанбаатар хотод долоо, Ховд аймагт гурав “Залуу сонгогчдын клуб” байгуулагдаж, 10 өсвөр үеийнхний клубийн гишүүдийг төслийн жижиг буцалтгүй тусламжаар өөрсдийн нөлөөллийн үйл ажиллагаа явуулахад сургаж, хүүхэд, залуучуудын боловсролыг дээшлүүлэх замаар ардчилсан засаглалыг одоо ба ирээдүйн сонгогчдын мэдлэг үйлдлээр дамжуулан бэхжүүлэхэд тодорхой хувь нэмэр оруулж ажиллалаа.

## "НИЙГМИЙН ЭГЭХ ХАРИУЦЛАГЫГ БЭХЖҮҮЛЭХ" ТӨСӨЛ

Дэлхийн Банк, Швейцарын Хөгжлийн Агентлаг болон Нийгмийн эгэх хариуцлагын Дэлхийн Түншлэлийн санхүүжилтээр 2016-2022 онд хэрэгжсэн Монгол Улсад Нийгмийн эгэх хариуцлагыг бэхжүүлэх төслийн хувьд төрөөс хариуцлага нэхэх, шаардахад гол үүрэг бүхий иргэний нийгмийн чадавхыг нэмэгдүүлэхэд чиглэн, уг төслийн үр дүнд нийгмийн эгэх хариуцлагын арга механизмын тусламжтай орон нутгийн түвшинд төрийн үйлчилгээг сайжруулах боломжтойг туршин харуулсан. Цаашид Нийгмийн эгэх хариуцлагыг бэхжүүлэх төслийн үр дүнг хадгалан, төсвийг улсын болон орон нутгийн түвшинд зохистой ашиглах, хяналт тавихад эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ, төсвийн хөрөнгө оруулалтын менежментийг дээшлүүлэх шаардлагатай. Төслийн өмнөх шатанд бий болсон чадавхад түшиглэн, орон нутаг дахь төсвийн хуваарилалт, төрийн үйлчилгээний үр дүнд хийх хяналт-шинжилгээг төрийн бодлого боловсруулах үйл явцтай холбох цогц үйл ажиллагааг дэмжин ажиллалаа. Монгол Улсын хэмжээнд нийгмийн эгэх хариуцлагыг бэхжүүлэх замаар эрүүл мэндийн салбарт төрийн хөрөнгө санхүүг зохистой зарцуулж төрийн үйлчилгээ, төрийн хөрөнгө оруулалтын үр дүнг нэмэгдүүлэхэд нөлөө үзүүллээ.






> “Нийгмийн эгэх хариуцлагыг бэхжүүлэх төслөөр иргэний нийгмийн болон төрийн байгууллагын мэдээлэл ашиглах, бодлого боловсруулалт, хэрэгжилтэд хяналт тавих чадавхыг нэмэгдүүлэн ажиллалаа.”



## "АРДЧИЛЛЫН ТӨЛӨӨХ ШИНЭ ҮЕ" ТӨСӨЛ

Иргэдийн оролцоо нь ардчилсан засаглалыг хамгаалах, хөгжүүлэх гол тулгуур учраас иргэний боловсролд ардчиллын үнэт зүйлсийн талаарх агуулга чухал байдаг. Үүнд залуучуудын байгууллага, хүүхдийн бүлгүүд зэрэг иргэний нийгмийн байгууллагуудад сайн дураараа суралцаж, өөрийгөө нээх боломжийг дэмжих нь зүйтэй гэж үзэн бид хичээлийн бус цагийн, ардчиллын үйл явцад залуусын оролцоог дээшлүүлэх 5 модуль сургалтын хөтөлбөрийг боловсруулсан. Хүний эрхийг хамгаалагч хүүхэд залуусын дуу хоолой ТББ сургалтын хөтөлбөрийг хүүхдүүдэд хүргэхээс өмнөх саналаа өгч зөвлөлдөн сургалтын хөтөлбөрийг үг хэллэг заах аргууд хүүхдүүдэд ойлгомжтой байхад анхааран боловсронгуй болгоход хамтран ажилласан. Сургалтын модулиудыг боловсруулахад Боловсролын хамтын ажиллагааны нийгэмлэг, Цогц хөгжлийн үндэсний төв, Хөөрхөн зүрхнүүд ТББ хамтран ажиллалаа.

## ГОЛ ҮР ДҮН

- Монгол Улсын боловсролын тогтолцооны ардчилсан засаглал, иргэдийн оролцоог сургах агуулга, арга зүйд хийсэн дүн шинжилгээ хийсэн.
- Зорилтот 15-19 насны залуучууд ардчиллын үнэт зүйлс, сонгуулийн үйл явцын талаарх мэдлэгээ дээшлүүлсэн.
- Ардчиллын үйл явц, мэтгэлцээнд оролцох хүүхэд, өсвөр үеийнхний туршлагыг бий болгон ажилласан.




> Бид “Өсвөр үеийн дуу хоолой” клуб байгуулж “Ардчилал ба ирээдүй” төслөө хэрэгжүүлсэн. Ардчиллын талаар зөв мэдээллийг түгээн дэлгэрүүлэх, ирээдүйгээ бүтээхэд хүн бүрийн оролцоо чухал болохыг таниулахыг зорьсон юм. Бидний зохион байгуулсан үйл ажиллагаануудад үе тэнгийн 200 гаруй сурагч оролцож, мэдлэгээ тэлсэн.

Нийслэлийн ерөнхий боловсролын 17 дугаар сургуулийн сурагч А.Анужин

## "НИЙГМИЙН ЭГЭХ ХАРИУЦЛАГЫГ БЭХЖҮҮЛЭХ" ТӨСӨЛ

Төслийн хүрээнд иргэд, иргэний нийгмийн байгууллагуудын улс, орон нутгийн төсөвт бүтээлчээр оролцох идэвх нэмэгдэж, уг үйл явцад хэрхэн оролцох арга замыг танилцууллаа. Ингэснээр төрийн мөнгө санхүүгийн төлөвлөлт, төсөвлөлтийн үйл явц иргэдээс тийм ч хол зүйл биш бөгөөд иргэд оролцсоноор тэдний төрөөс авах үйлчилгээний чанар, хүртээмж сайжрах боломжтой болохыг илрүүлсэн.



## ГОЛ ҮР ДҮН

Орон нутгийн иргэд, иргэний нийгмийн байгууллагуудыг чадавхжуулан, улс болон орон нутгийн төсвийн төлөвлөлт, төсөвлөлт, гүйцэтгэлийн шатанд оролцох оролцооны хууль эрх зүйн үндсийг танилцуулан, төсөвт тавих иргэдийн хөндлөнгийн хяналтын явцад бүтээлчээр оролцох мэдлэгийг олгон, иргэдэд олгогдож буй оролцооны арга замыг таниулах үйл ажиллагааг явуулсан.

Орон нутгийн иргэдийн идэвхийг сэргээж, төрийн төсвийн үйл ажиллагаанд иргэд, иргэний нийгмийн байгууллагууд нэгэн цул болж болж оролцон, төртэй нөхөрсгөөр, харилцан ярилцаж, хамтын шийдлийг гарган оролцохын ач холбогдлыг таниулсан.

> Энэхүү төсөл нийгмийн эгэх хариуцлагыг бэхжүүлэх замаар эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээний чанарыг сайжруулах, эрүүл мэндийн салбарын төсвийг зохистой, үр ашигтай төлөвлөх, төсөвлөх, зарцуулахад иргэд, иргэний нийгмийн байгууллагын үр дүнтэй оролцоог дэмжихэд чухал үүрэг гүйцэтгэсэн гэж бодож байна. Манай аймгийн иргэд олон сургалтад хамрагдаж, төрийн байгууллагууд иргэдтэйгээ хэрхэн үр дүнтэй хамтран ажиллах, төрийн байгууллагыг үйл ажиллагаа иргэдэд ил тод нээлттэй байх, иргэн, төр хоёр үр дүнтэй хамтран ажиллах талаар олон талын мэдлэгтэй болсон. "Монгол Улсад ил тод байдал, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэхэд нийгмийн эгэх хариуцлагыг бэхжүүлэх нь" төслийг санхүүжүүлсэн Швейцарын Хөгжлийн Агентлаг, Дэлхийн Банкинд баярласнаа илэрхийлье.

Дундговь аймгийн Засаг дарга Ц.Мөнхбат



## “УЛААНБААТАР ХОТЫН ГЭР ХОРООЛОЛД ХҮРТЭЭМЖТЭЙ, ТААТАЙ ОРЧИН БҮРДҮҮЛЭХЭД ЗАЛУУСЫН ОРОЛЦООГ НЭМЭГДҮҮЛЭХ” ТӨСӨЛ

Хүүхдийг Ивээх Сан “Улаанбаатар хотын гэр хороололд хүртээмжтэй, таатай орчин бүрдүүлэхэд залуусын оролцоог нэмэгдүүлэх” төслийг Азийн Хөгжлийн Банкны санхүүжилтээр 2022 оны 6 дугаар сараас хэрэгжүүлж байна. Энэ төсөл гэр хорооллын орчныг сайжруулахад залуучуудын утга учиртай оролцоог хангах зорилготой юм. Төслийн тайлант хугацаанд Улаанбаатар хотын Баянхошуу (Сонгинохайрхан дүүргийн 7-11, 28 болон 40-р хороо) болон Сэлбэ (Чингэлтэй дүүргийн 14, 18-р хороо болон Сүхбаатар дүүргийн 13, 14-р хороо) бүсийн 18-30 насны залуучуудын оролцоонд тулгуурласан “Залуу элч хөтөлбөр” хэрэгжүүлж, нийт 66 залуучууд хамрагдлаа. Эдгээр залуучуудын оролцоогоор тухайн орон нутгийн залуучуудаас нөхцөл байдлын судалгаа авч, хот төлөвлөлт, байгуулалт болон засаглалын хүрээнд тэдний дуу хоолойг сонсов. Хөтөлбөрийн төгсгөлд эдгээр залуучууд “Хүртээмжтэй, таатай орчин” сэдвийн дор өөрсдийн санаачилсан төслөө хэрэгжүүлнэ. Ингэснээр төслийн хүрээнд залуучуудын оролцоо, нөхцөл байдал, тэдний хүсэл эрмэлзлийг судлахаас гадна, тэднийг хөтөлбөрийн хүрээнд сурсан мэдлэгээ бататгах боломж бүрдүүлж байгаа юм.

> “18-30 насны залуучуудын оролцоонд тулгуурласан “Залуу элч хөтөлбөр” хэрэгжүүлж, нийт 66 залуучууд хамрагдлаа.”



## ГОЛ ҮР ДҮН

**5** Төслийн зорилтот залуучуудын оролцоог тандан судалж, “Залуу элч хөтөлбөр”-ийг боловсруулан, оролцох залуусыг сонгон шалгаруулав. Сонгогдсон залуу манлайлагч нарт зориулан гэр хорооллын тогтвортой хөгжил, хот төлөвлөлт, залуусын оролцоо, манлайлал зэрэг чиглэлээр 5 багц сургалтын агуулга боловсруулав.

**150** Баянхошуу дэд төвд Баянхошуу, Сэлбэ бүсийн нийт 11 хорооны 18-30 насны 150 гаруй залуучуудыг 5 багц сургалтад хамруулав. Уг сургалтыг оролцоонд тулгуурлан явуулсан бөгөөд орон нутгийн хөтөлбөрт хамрагдсан 11 залуу манлайлагч удирдан чиглүүлж ажилласнаараа онцлогтой байв.

**600** Орон нутгийн 600 орчим залуусыг хамруулсан нөхцөл байдлын судалгаар “Залуу элч хөтөлбөр”-ийн оролцогчдын тусламжтай гүйцэтгэв. Уг судалгаа нь чанарын болон тоон аргаар хийгдсэн бөгөөд залуучуудыг өргөнөөр хамруулахын тулд олон янзын арга барил ашигласан байна.





“Би СХД-ийн 8-р хороонд 13 жил амьдарч байна. Би залуу ээж. Миний амьдарсан энэ орчинд үр хүүхэд минь дахиад 13 жил амьдрах уу гэж би өөрөөсөө асуусан. Орчин нөхцөлөө сайжруулах, хөгжүүлэхэд бага ч гэсэн хувь нэмэр болохыг хүссэн учраас би энэ хөтөлбөрт оролцож, охинтойгоо хамт 5 шатны сургалтаа огт таслалгүй суусан. Нийгмийн үйлчилгээг тэгш хүртээмжтэй, хэнийг ч орхилгүй хүргэх тухай сэдэв надад их таалагдсан. Цар тахлын улмаас хүүхдүүд хичээл завсардсан. Тийм учраас би цаашдаа сургуулийн насны хүүхдүүдийн хичээлийн хоцрогдлыг арилгах чиглэлээр ажиллана гэж бодож байна.”

**“Залуу манлайлагч” Ч.Ариунзаяа**

## “ОРОН НУТГИЙН ӨСВӨР ҮЕИЙНХЭНД ХУВЬ ХҮНИЙ УР ЧАДВАР, ЭНТРЕПРЕНЕРШИП БОЛОВСРОЛ ОЛГОХ” ТӨСӨЛ

Япон Улсын “Нийгмийн хөгжлийн сан”-гийн санхүүжилт, Дэлхийн банкны менежменттэй хэрэгжиж буй “Орон нутгийн өсвөр үеийнхэнд хувь хүний ур чадвар, энтрепренершип боловсрол олгох" төсөл (2019-2023) нь өсвөр үеийн хүүхэд, залуучуудад хувь хүний ур чадвар, энтрепренершипийн боловсрол олгох замаар сурлагын амжилтыг сайжруулж, цаашлаад хөдөлмөр эрхлэлтэд бэлдэх зорилготой.

Төсөл нь Монгол Улсын баруун, зүүн, төвийн болон хангайн бүсийн төлөөлөл болох Ховд, Завхан, Өвөрхангай, Говьсүмбэр, Сүхбаатар аймгийн ядуурлын түвшин өндөртэй, алсдагдсан 25 сумын 14-25 насны 6,000 өсвөр насны хүүхэд, залуучуудад сургуульд болон хөдөлмөрийн зах зээлд өндрөөр үнэлэгддэг хувь хүний ур чадваруудыг хөгжүүлэх сургуульд суурилсан, орон нутгийн залуучууд өсвөр үеийнхний оролцоотой сургалтын хөтөлбөр хэрэгжүүлж байна. Түүнчлэн хөтөлбөрөөс сурсан мэдлэгээ бодитоор турших боломж олгон, өсвөр үеийнхний боловсруулсан бичил төслийг санхүүжүүлж, дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаануудыг зохион байгуулж ажиллалаа.



“Орон нутгийн өсвөр үеийнхэнд хувь хүний ур чадвар, энтрепренершип боловсрол олгох нь” төсөл бол цар тахлын үед боловсролын салбар хоцрогдож, сургуулиуд удаан хугацаанд завсарласан ийм хүнд цаг үед алслагдсан аймгуудад туслалцаа, дэмжлэг хэрэгтэй байгаа хүүхэд, залууст хүрч чадсан сайн төсөл юм. Төсөл оролцогч бүх хүндээ хүрч, олон чадвар бий болгож, богино хугацаанд үр дүнгээ өгч байна. Мөн бидний олон жил ярьж, хэрэгжүүлж чадахгүй байсан, бүх сургуулиуд, боловсролын бүх түвшинд хэрэгжүүлэх шаардлагатай төсөл байгаа юм.”

Монгол Улсын Их Хурлын гишүүн, Засгийн газрын гишүүн, Боловсрол, шинжлэх ухааны Сайд Л.Энх-Амгалангийн үндэсний семинарын үеэр хэлсэн үгнээс.



## ГОЛ ҮР ДҮН

- 2022 онд, зорилтот 5 аймгийн 25 сумын хүүхэд, залуус “Энтрепренерт суурилсан хувь хүний ур чадварын хөгжүүлэх сургалт”-ын (ESEL) хөтөлбөрт хамрагдан, өөртөө итгэх итгэл, хувь хүний онцлогийг таних, цагийн менежмент, багаар ажиллах, ялгаатай хэрэгцээг таних, санхүүгийн нөөцийг хуваарилах, ашиглах, эрсдэлийг урьдчилан харах, бизнесийн төсөл боловсруулах зэрэг ур чадварт суралцлаа. 2022 онд нийт 3,114 хүүхэд, залуус ESEL сургалтын хөтөлбөрт хамрагдсан бөгөөд 2021 онтой харьцуулахад 1,000 гаруй оролцогчоор өссөн үзүүлэлттэй байна. Төсөл хэрэгжиж эхэлснээс хойш нийт 5,216 хүүхэд, залуус төслийн үр шимийг хүртээд байна.
- ESEL сургалтыг чиглүүлэн явуулах сургагч багшийг бэлтгэх сургалтад 243 багш оролцож ESEL сургалтын сургагч багшаар бэлтгэгдэв.
- Насан туршийн боловсролын төвийн залуусын сургалтын хэрэгцээ, суралцах арга барилын онцлогт тохируулан ESEL сургалтын хөтөлбөрийг танхимын болон зайн хосолсон хэлбэрээр 10 суманд хэрэгжүүлж эхэллээ.
- ESEL сургалтын хөтөлбөрт хамрагдаж, амжилттай төгссөн хүүхэд, залуучууд хамтдаа баг болон орон нутагтаа хэрэгжүүлэх бизнес санаануудаа боловсруулж, Pitch арга хэмжээний үеэр танилцуулан, шалгарсан төслүүд нь санхүүгийн дэмжлэг авч, сургалтаар олж авсан мэдлэг, ур чадвараа практикт хэрэгжүүлж байна. Бичил төслийн уралдаанд 1,000 гаруй хүүхэд, залуус оролцсоноос талаас дээш хувь нь буюу 600 орчим нь санхүүжилт авч төслүүдээ хэрэгжүүлж байна.
- Төслийн орон нутгийн оролцогч талууд болон БШУЯ-ны санал, хүсэлтийн дагуу ESEL сургалтыг 5 аймгийн 6 Политехник коллеж/Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвүүд дээр хэрэгжүүлсэн бөгөөд сургалтад 140 залуус хамрагдаж хувь хүний ур чадвараа хөгжүүлэв.
- Орон нутгийн нөөц бололцоо, олон нийтийн хэрэгцээнд тулгуурлан, энтрепренершип ойлголтыг сумандаа нутагшуулах зорилго бүхий Сургуульд суурилсан энтерпрайз төслийг зорилтот 5 аймгийн шалгарсан 5 сум буюу Өвөрхангай аймгийн Богд, Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан, Ховд аймгийн Зэрэг, Завхан аймгийн Тэлмэн болон Говьсүмбэр аймгийн Сүмбэр суманд тус тус хэрэгжүүлж эхэллээ.



> Томоор мөрөөд, жижгээр эхэл гэхдээ хамгийн чухлаас нь эхэл" гэсэн үгэнд дуртай. Учир нь авьяасгүй хүн гэж байдаггүй, харин өөрийн айдсаа даван туулах чадваргүй хүн л байдаг юм шиг санагдсан. Би өөрөө аймхай, түүнийгээ ичимхий гэдэг үгээр далдалдаг байсан болохоор шинэ сургууль шинэ орчинд өөрийгөө бага багаар нээж эхэлсэн минь амжилтын маань эхлэл болсон.

Өвөрхангай Политехникийн коллежийн сурагч, ESEL хөтөлбөрийн төгсөгч Э.Хоролням





Хүүхдийг Ивээх Сангийн ажилтан А.Дэлгэрмаа Өвөрхангай аймгийн Гучин-Ус сумын ЕБС-ийн сурагчидтай ярилцаж байгаа нь.

© NYAMDAVAA YONDONJAMTS/SAVE THE CHILDREN 2022

## ОЛОН УЛСЫН ӨСВӨРИЙН ЭНТРЕПРЕНЕРҮҮДИЙН УРАЛДААН

Хүүхдийг Ивээх Сан, “Хөгжлийн шийдэл” ТББ, Нийслэлийн Бизнес инновац хөгжлийн газартай хамтран Global Youth Entrepreneurship Challenge (GYEC) буюу Олон улсын өсвөрийн энтрепренерүүдийн уралдааныг зургаа дахь жилдээ зохион байгууллаа. Оролцогчид 12 цагийн дотор бизнес санаагаа боловсруулж, түүнийхээ дагуу бүтээгдэхүүний загвар гаргаж, бизнес төлөвлөгөөгөө танилцуулж өрсөлдөв. Энэ удаагийн тэмцээний сэдэв нь загас агнуур, далайн хүчиллэгжилт, бохирдол, далайн ухмэл бүс, хог хаягдал зэрэг дэлхий нийтэд тулгамдаж буй байгаль орчны асуудлыг шийдэх байв.

Тэмцээний тэргүүн байранд Монгол Тэмүүлэл сургуулийн баг, удаах байранд Хобби сургуулийн баг, 3 дугаар байранд Орчлон сургуулийн баг тус тус шалгарлаа. Тэд Япон Улсын “Center for Entrepreneurship Development” байгууллагаас зохион байгуулдаг өсвөр үеийнхний бүтээлч сэтгэлгээг шинжлэх ухаантай уялдуулан хөгжүүлэх зорилго бүхий Олон Улсын Өсвөрийн Энтрепренеруудын цахим тэмцээнд эх орноо төлөөлөн оролцсон юм.






## "МОНГОЛ УЛСАД КОВИД-19 ЦАР ТАХЛЫН ЭСРЭГ ХАРИУ АРГА ХЭМЖЭЭГ САЙЖРУУЛАХАД ТЕХНИКИЙН ТУСЛАЛЦАА ҮЗҮҮЛЭХ, ЗОРИЛТОД НИЙЦҮҮЛЭН ТАРХВАРЗҮЙН ХЯНАЛТЫГ ДЭМЖИХ НЬ" ТӨСӨЛ

Хүүхдийг Ивээх Сан анх удаа эрүүл мэндийн хөтөлбөрийн хүрээнд томоохон төслийг амжилттай хэрэгжүүлж дууслаа. АНУ-ын Олон улсын хөгжлийн агентлагийн санхүүжилтээр “Монгол Улсад КОВИД-19 цар тахлын эсрэг хариу арга хэмжээг сайжруулахад техникийн туслалцаа үзүүлэх, зорилтод нийцүүлэн тархварзүйн хяналтыг дэмжих нь” төслийг АНУ-ын FHI 360 байгууллагатай хамтран хэрэгжүүллээ.

Мөн 330 суманд 800 хүчилтөрөгчийн баллоныг дагалдах хэрэгслийн хамт хүлээлгэн өгч, 21 аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлгүүд, төв болон төрөлжсөн нарийн мэргэжлийн эмнэлгүүдийн 45 инженерийг сургалтад хамруулсан юм.

Энэ хөтөлбөрийн хүрээнд АНУ-д төвтэй “Денан төсөл”-ийн санхүүжилтээр Говь-Алтай аймгийн Чандмань сумын Эрүүл мэндийн төвд орчин үеийн иж бүрэн тоног төхөөрөмж бүхий бүхий амны хөндийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг цогцоор нь үзүүлэх боломжтой шүдний кабинет байгуулан, хүлээлгэн өглөө.





> “Энэхүү төсөл Монгол орны бүх аймаг, сум, нийслэл хотыг хамарч, 21 аймгийн 330 сумын 660 гаруй эмч, эмнэлгийн ажилтнуудыг сургалтад хамрууллаа.”

# ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨТӨЛБӨР

“Монгол Улсад КОВИД-19 цар тахлын эсрэг хариу арга хэмжээг сайжруулахад техникийн туслалцаа үзүүлэх, зорилтод нийцүүлэн тархварзүйн хяналтыг дэмжих нь” төсөл нь Монгол улсад КОВИД -19-ийн халдварын тархалтыг бууруулахын тулд эрүүл мэндийн тогтолцоог бэхжүүлэх мөн хариу арга хэмжээнд бэлтгэх, халдвараас сэргийлэх ажиллагаанд дэмжлэг үзүүлэх зорилготой.

> “Ингэхдээ амьсгалын аппаратын дэмжлэг, хэрэглээг сайжруулах, анхан шатны эрүүл мэндийн байгууллагын түвшинд Хүчилтөрөгчийн экосистем бүрдүүлэх, эмч мэргэжилтнүүдийн чадавхыг сайжруулах үйл ажиллагаануудыг амжилттай хэрэгжүүллээ.”







## ГОЛ ҮР ДҮН

**114**

Амьсгалын аппаратын дэмжлэг: 11 аймгийн 12 Нэгдсэн эмнэлгийг сонгож, 50 ширхэг аппаратыг хандивласан бөгөөд эдгээр аппаратыг ашиглах эмнэлгийн мэргэжилтнүүдэд сургалтууд зохион байгууллаа. Мөн 21 аймаг, нийслэлийн 9 дүүргийн нэгдсэн эмнэлгүүдийн эрчимт эмчилгээний нийт 114 эмч, сувилагч нарт “КОВИД-19-ийн халдварын хүндрэлтэй, амь тэнссэн өвчтөнд зохиомол амьсгалын дэвшилтэт аргыг хэрэглэх” сэдэвт сургалтыг бүсчилсэн байдлаар зохион байгуулав.

**665**

Анхан шатны эрүүл мэндийн байгууллагын түвшинд КОВИД-19-ийн халдварын эмнэлзүйг удирдах, цар тахлын бэлэн байдал, яаралтай тусламжийн чиглэлээр чадавхжуулах сургалтыг шаталсан байдлаар орон даяар зохион байгуулж 20 Мастер сургагч, 42 сургагчаар бэлтгэн 21 аймгийн бүх сумдын 665 эмч, сувилагчийг хамруулж чадлаа.

## 800

Хүчилтөрөгчийн экосистем, эмчилгээний чадавхын түргэвчилсэн үнэлгээг бүх аймаг сумдын түвшинд явуулж, үнэлгээний үр дүн дээр ЭМЯ-тай зөвлөлдсөний үндсэн дээр хүчилтөрөгчийн 10 литрийн баллон, дагалдах хэрэгслүүд, хүчилтөрөгчийн маскийн хамт нийт 800 багцыг худалдан авч ЭМЯ-нд хандивласнаар 21 аймгийн бүх суманд тараагдлаа.

## 45

Эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженерүүдийг чадавхжуулах сургалтыг АНУ-ын Ассист Интернэшнл байгууллагатай хамтран зохион байгуулж, улсын бүх шатлалын эмнэлгүүдийн нийт 45 инженерүүдийг хамрууллаа.

" КОВИД-19-ийн үеэр амьсгалын дутагдалтай өвчтөний тоо богино хугацаанд хэт олноор нэмэгдэж, аппаратын тоо хүрэлцэхгүй болж эхэлсэн. Яг л ийм хэрэгцээ шаардлагатай тулгамдсан үед төслийн зүгээс тоног төхөөрөмжөөр дэмжлэг үзүүлж, зэрэгцүүлэн эмч, сувилагч, эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженерүүдэд аппаратын ашиглалтын талаар сургалт явуулсан нь цагаа олсон дэмжлэг байлаа. Зөвхөн амьсгалын аппарат биш хүчилтөрөгчийн үйлдвэрийг аймгийн төвүүдэд байгуулсан нь чухал ажил болсон. "

Эрүүл мэндийн яамны Анхан болон лавлагаа шатлалын тусламжийн хэлтсийн дарга Г.Навчаа






Баруун талаас Хүүхдийг Ивээх Сангийн ажилтан Б.Гантулга, Б.Номин Дорнод аймгийн нэгдсэн эмнэлэгт хүчилтөрөгчийн экосистемийн үнэлгээ хийж байгаа нь.

## ДЕНАН ТӨСӨЛ

Хүүхдийг Ивээх Сан АНУ-д төвтэй “Денан төсөл”-ийн санхүүжилтээр Эрүүл мэндийн төслийг Архангай аймгийн Эрдэнэмандал суманд 2017 оноос, Говь-Алтай аймгийн Чандмань суманд 2022 оноос хэрэгжүүлж байна. Энэхүү төслийг Архангай аймгийн Тариат суманд 2012-2021 онд амжилттай хэрэгжүүлсэн юм.








## ГОЛ ҮР ДҮН

**437**

Говь-Алтай аймгийн Чандмань сумын Эрүүл мэндийн төвд орчин үеийн иж бүрэн тоног төхөөрөмж бүхий амны хөндийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг цогцоор нь үзүүлэх боломжтой шүдний кабинет байгуулан, 2022 оны 11 дүгээр сард хүлээлгэж өглөө. 2022 онд шүдний кабинетаар Чандмань сумын цэцэрлэгийн 3-5 настай 54, Ерөнхий боловсролын 1-р ангийн 2 бүлгийн 6 настай 27 хүүхдэд урьдчилсан сэргийлэх үзлэг хийж, сургалт зөвлөгөө өгөв. Нийт дөрвөн сумын 437 хүнд шүдний тусламж үйлчилгээ үзүүлсэн байна.

**14**

2022 оны 10 дугаар сард Архангай аймгийн Эрдэнэмандал сумын Эрүүл мэндийн төвд эмнэлэгт зөөврийн дижитал рентген аппарат хүлээлгэж өгсөн бөгөөд өнгөрсөн онд гэмтэлтэй 14 хүн рентген зураг авахуулсан байна. Сумын эмнэлэгт бүх төрлийн хурц болон архаг өвчнүүд ялангуяа дотрын өвчин, амьсгалын замын эмгэгүүд, гэмтэл, яаралтай тусламжийн тохиолдлуудад оношилгоо хийхэд рентген аппарат чухал хэрэгцээтэй байдаг.

Орон нутгийн эмнэлгүүдэд явуулын оношилгоо, үйлчилгээ хийх, мэдээллээ шуурхай нэгтгэх, сүлжээтэй газарт интернэтэд холбогдох хэрэгцээ шаардлага гардаг тул Архангай аймгийн Тариат, Эрдэнэмандал сумын Эрүүл мэндийн төвүүдэд зөөврийн шинэ компьютер өгөв.

# 2022 ОНД ХЭВЛЭГДСЭН НОМ, БҮТЭЭЛ



2021 оны жилийн тайлан



Хүүхдийг Ивээх Сангийн 2021 оны амжилтын түүхүүдийн цахим сэтгүүл



Хамтдаа дэвшин суралцъя гарын авлага



Хүүхдийг Ивээх Сангийн улирал тутмын цахим сонин дугаар 1



Хүүхдийг Ивээх Сангийн улирал тутмын цахим сонин дугаар 2



Хүүхдийг Ивээх Сангийн улирал тутмын цахим сонин дугаар 3



Хүүхдийг Ивээх Сангийн улирал тутмын цахим сонин дугаар 4



Тэгш хамруулах боловсрол - “5 дугаар ангийн сурагчдыг бага ангиас дунд ангид дэвшин суралцахад дэмжлэг үзүүлэх арга зүй” сургалтын модуль



Тэгш хамруулах боловсрол - “ЕБС-ийн дунд ангийн багш нарт зориулсан мэргэжил дээшлүүлэх сургалтын модуль”



Тэгш хамруулах боловсрол - “Хүүхдийн сурах үйл явцад эцэг эхчүүдийн оролцоог нэмэгдүүлэх арга зүй” сургалтын модуль



Сургалтын үйл ажиллагааг дэмжих тусгай хэрэгцээт боловсролын арга зүй



Хүүхдийн хөгжлийг дэмжих танхим


“Хүүхэд бүрийг боловсролд тэгш хамруулах зарчмыг дэмжих нь-2” төслийн мэдээллийн хуудас #3



“Хүүхэд бүрийг боловсролд тэгш хамруулах зарчмыг дэмжих нь-2” төслийн мэдээллийн хуудас #4



“Хүүхэд бүрийг боловсролд тэгш хамруулах зарчмыг дэмжих нь-2” төслийн 2 дахь шатны суурь судалгааны тайлан










Тэгш хамруулах соёлыг түгээх, хандлага ойлголтыг өөрчлөх зорилготой “Хамтдаа” нөлөөллийн аяны цуврал постерууд



“Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй малчин эцэг эхчүүдийн бичиг үсгийн боловсролыг дээшлүүлэх замаар хүүхдийнхээ сурч хөгжих болон сайн сайхан байдлыг дэмжих чадавхыг сайжруулах нь” төслийн танилцуулга



"Тэгш боломжийг бүрдүүлэх замаар суралцахуйг дэмжих нь" төслийн танилцуулга





Бидний амжилтын түүх – бидний ажлын түүх “Монгол Улсад Хүүхэд хамгааллын тогтолцоог бэхжүүлэх нь” төслийн амжилтын түүхүүдийн эмхэтгэл



Жендэрт суурилсан хүчирхийллийн хохирогчид үйлчилгээ үзүүлэх түр хамгаалах байр, нэг цэгийн үйлчилгээний төвийн стандартыг үнэлэх судалгааны тайлан



“Охидыг хүчирхийлэл, мөлжлөгөөс хамгаалах нь” төслийн нөхцөл байдлын үнэлгээний тайлан



“Охидыг хүчирхийлэл, мөлжлөгөөс хамгаалах нь” төслийн суурь судалгааны тайлан



Энтрепренершипт суурилсан хувь хүний ур чадварыг хөгжүүлэх сургалтын шинэчилсэн хөтөлбөр



Энтрепренершипт суурилсан хувь хүний ур чадварыг хөгжүүлэх сургалт, Багш/Зөвлөхийн гарын авлага, шинэчилсэн хувилбар




Энтрепренершипт суурилсан хувь хүний ур чадварыг хөгжүүлэх сургалт, Суралцагчийн гарын авлага, шинэчилсэн хувилбар




Энтрепренершипт суурилсан хувь хүний ур чадварыг хөгжүүлэх Хосолсон сургалтын Багшид зориулсан гарын авлага




Энтрепренершипт суурилсан хувь хүний ур чадварыг хөгжүүлэх Хосолсон сургалтын суралцагчдад зориулсан гарын авлага



“Төслийн Санал, гомдлын механизм” номын хавчуурга



“Бизнесийн бүх байгууллагад баримтлах зарчмууд” номын хавчуурга




"Эрүүл мэндийн тогтолцооны бүх шатанд Ковид-19-ийн халдварын эмнэлзүйн тусламж үйлчилгээг удирдахуй” Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээний ажилтнуудад зориулсан гарын авлага






Насанд хүрэгсдийн эрчимт эмчилгээний үеийн тайвшруулалтын протокол




Насанд хүрэгсдийн дэмийрлийн үед үзүүлэх тусламжийн протокол




Насанд хүрэгсдийн эрчимт эмчилгээний үеийн Амьсгалын цочмог дистресс хам шинжийн протокол




Насанд хүрэгсдийн эрчимт эмчилгээний үеийн түрүүлэг харуулах протокол




Насанд хүрэгсдийн эрчимт эмчилгээний тасагт зохиомол амьсгалын улмаас үүссэн уушгины хатгаанаас сэргийлэх протокол




Насанд хүрэгчдийн эрчимт эмчилгээний үеийн зохиомол амьсгалын аппаратаас төсөөрүүлэх протокол




Насанд хүрэгсдийн эрчимт эмчилгээний тасагт эмчлүүлэгчдийг тэжээх протокол




Насанд хүрэгсдийн эрчимт эмчилгээний тасагт хийгдэх эрт үеийн хөдөлгөөн эмчилгээний протокол




Анафилаксийн үеийн тусламжийн протокол




Амь тэнссэн өвчтөний үндсэн үнэлгээ, тусламжийн протокол




Анафилаксийн үеийн, Хүчилтөрөгч эмчилгээг титрлэн хийх, Цар тахлын үеийн гэрээр өгөх эмчилгээ, сувилгааны зөвлөмж сэдэвтэй 3 төрлийн постер




“BASIC for COVID” онлайн сургалтын платформ




“Эрүүл бие эрхэм баялаг” - “Монгол Улсад Ковид-19 цар тахлын эсрэг хариу арга хэмжээг сайжруулахад техникийн туслалцаа үзүүлэх, зорилтод нийцүүлэн тархварзүйн хяналтыг дэмжих нь“ төслийн амжилтын түүхүүдийн эмхэтгэл



“Монгол Улсад Ковид-19 цар тахлын эсрэг хариу арга хэмжээг сайжруулахад техникийн туслалцаа үзүүлэх, зорилтод нийцүүлэн тархварзүйн хяналтыг дэмжих нь“ төслийн танилцуулга


Тэгш хамруулах соёлыг түгээх, хандлага ойлголтыг өөрчлөх зорилготой “Хамтдаа” нөлөөллийн аяны видео бүтээлүүд


Тэгш хамруулах соёлыг түгээх, хандлага ойлголтыг өөрчлөх зорилготой “Хамтдаа” нөлөөллийн аяны видео бүтээлүүд



Тэгш хамруулах соёлыг түгээх, хандлага ойлголтыг өөрчлөх зорилготой “Хамтдаа” нөлөөллийн аяны видео бүтээлүүд


Тэгш хамруулах соёлыг түгээх, хандлага ойлголтыг өөрчлөх зорилготой “Хамтдаа” нөлөөллийн аяны видео бүтээлүүд


"Боловсролын тусгай хэрэгцээтэй хүүхдүүдийн малчин эцэг, эхчүүдийн бичиг үсгийн боловсролыг сайжруулах нь" төслийн үр дүнгийн видео цуврал


"Боловсролын тусгай хэрэгцээтэй хүүхдүүдийн малчин эцэг, эхчүүдийн бичиг үсгийн боловсролыг сайжруулах нь" төслийн үр дүнгийн видео цуврал


"Боловсролын тусгай хэрэгцээтэй хүүхдүүдийн малчин эцэг, эхчүүдийн бичиг үсгийн боловсролыг сайжруулах нь" төслийн үр дүнгийн видео цуврал


"Боловсролын тусгай хэрэгцээтэй хүүхдүүдийн малчин эцэг, эхчүүдийн бичиг үсгийн боловсролыг сайжруулах нь" төслийн үр дүнгийн видео цуврал


Говь-Алтай аймгийн Чандмань суманд Денан төслийн хүрээнд орчин үеийн иж бүрэн шүдний кабинет байгуулсан тухай видео




Энтрепренершипд суурилсан хувь хүний ур чадвар хөгжүүлэх сургалтын (ESEL) танилцуулга


ESEL сургалтаас суралцагчдад гарч буй өөрчлөлт


Өсвөр үеийнхэнд хувь хүний ур чадвар, энтрепренершип боловсрол олгох төслийн үндэсний семинар


Өсвөр үеийнхэнд хувь хүний ур чадвар, энтрепренершип боловсрол олгох төслийн явцын үр дүн


“Ардчиллын төлөөх шинэ үе” төслийн үр дүнгийн видео


“Нийгмийн эгэх хариуцлагыг бэхжүүлэх нь” төслийн Дорнод аймгийн үр дүнгийн талаарх видео


“Нийгмийн эгэх хариуцлагыг бэхжүүлэх нь” төслийн Өмнөговь аймаг болон Улаанбаатар хотод гарсан үр дүнгийн талаарх видео


“Охидыг хүчирхийлэл, мөлжлөгөөс хамгаалах нь” төслийн хүрээнд хийсэн Хүчирхийллийг даван туулагчдад зориулсан видео



“Охидыг хүчирхийлэл, мөлжлөгөөс хамгаалах нь” төслийн хүрээнд хийсэн Үйлчилгээ үзүүлэгчдэд зориулсан видео

# САНХҮҮГИЙН ТАЙЛАН

- 751,855 Японы Нийгмийн Хөгжлийн Сан/Дэлхийн банк
- 265,228 Хүүхдийг Ивээх Сан (Япон)
- 3,528 Бусад
- 41,902 Азийн Хөгжлийн Банк
- 70,850 GPE (Global partnership for education) сан
- 4,100 Австралийн Элчин Сайдын Яам
- 38,774 Денан Төсөл (АНУ)
- 665,859 Японы Гадаад хэргийн яам




- 225,613 FHI 360
- 170,170 НҮБ-ын Эмэгтэйчүүдийн Сан
- 121,764 Швейцарын Хөгжлийн Агентлаг/Дэлхийн Банк
- 146,673 Японы Олон улсын хамтын ажиллагааны байгууллага (ЖАЙКА)
- 50,576 НҮБ-ын Ардчиллыг дэмжих сан



# САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

| *(Ам доллараар)* | 2022 | 2021 |
|---|---|---|
| **ХӨРӨНГӨ** | | |
| **Эргэлтийн хөрөнгө** | | |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө | 678,878.42 | 1,129,744.07 |
| Авлага | 319,095.97 | 90,899.65 |
| Урьдчилж төлсөн зардал, тооцоо | 604.85 | 2,339.37 |
| **Нийт эргэлтийн хөрөнгө** | **998,579.24** | **1,222,983.09** |
| **Эргэлтийн бус хөрөнгө** | | |
| Үндсэн хөрөнгө | 172,680.44 | 125,696.81 |
| **Нийт эргэлтийн бус хөрөнгө** | **172,680.44** | **125,696.81** |
| **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН** | **1,171,259.68** | **1,348,679.90** |
| **ӨР ТӨЛБӨР БА ЦЭВЭР ХӨРӨНГӨ** | | |
| **Өр төлбөр** | | |
| Дансны болон бусад өглөг | 8,026.37 | 15,914.27 |
| Цалингийн өглөг | 682.31 | 43.25 |
| Татвар, шимтгэлийн өглөг | 10,960.22 | 820.27 |
| **Богино хугацаат өр төлбөрийн дүн** | **19,668.90** | **16,777.79** |
| **Урт хугацаат өр төлбөр** | | |
| Нөөц ба өр төлбөр | 221,535.74 | 245,665.76 |
| Хойшлуулсан орлого | 172,680.44 | 125,696.81 |
| **Урт хугацаат өр төлбөрийн дүн** | **394,216.18** | **371,362.57** |
| **Нийт өр төлбөрийн дүн** | **413,885.08** | **388,140.36** |

| | | |
|---|---|---|
| **Цэвэр хөрөнгө** | | |
| Хязгаарлалттай нөөц | 397,385.37 | 537,554.11 |
| Үндсэн хөрөнгийн сан | 105,221.45 | 140,208.71 |
| Хуримтлагдсан үр дүн | 254,767.78 | 282,776.72 |
| **Цэвэр хөрөнгийн дүн** | **757,374.60** | **960,539.54** |
| **ӨР ТӨЛБӨР БА ЦЭВЭР ХӨРӨНГИЙН ДҮН** | **1,171,259.68** | **1,348,679.90** |

# ОРЛОГО БОЛОН ЗАРЦУУЛАЛТЫН ТАЙЛАН

| *(Ам доллараар)* | 2022 | 2021 |
|---|---|---|
| **Орлого:** | | |
| Төсөл хөтөлбөрийн орлого | 2,556,891.29 | 1,785,689.25 |
| Хандив, тусламжийн орлого | - | 1,510.07 |
| Бусад орлого | 22,193.70 | 2,888.94 |
| **Нийт орлогын дүн** | **2,579,084.99** | **1,790,088.26** |
| **Зардал:** | | |
| Төсөл хөтөлбөрийн зардал | 2,312,382.54 | 1,598,939.24 |
| Ерөнхий удирдлагын зардал | 244,622.71 | 188,127.45 |
| **Нийт зардлын дүн** | **2,557,005.25** | **1,787,066.69** |
| **Үйл ажиллагааны үр дүн** | **22,079.74** | **3,021.57** |
| Үйл ажиллагааны бус орлого (зардал) | 19,607.31 | 11,822.61 |
| Валютын ханшийн зөрүүгийн олз (гарз) | (69,695.99) | (2,446.96) |
| **Тайлант жилийн үр дүн** | **(28,008.94)** | **12,397.22** |



# ХАМТРАГЧ, САНХҮҮЖҮҮЛЭГЧ БАЙГУУЛЛАГУУД

## САНХҮҮЖҮҮЛЭГЧ БАЙГУУЛЛАГУУД

- Азийн Хөгжлийн Банк
- Австралийн сайн дурынхны хөтөлбөр
- АНУ-ын Олон улсын хөгжлийн агентлаг
- Боловсролын Дэлхийн Түншлэл
- Денан Төсөл
- Дэлхийн Банк
- Михира корпораци, Япон
- Нийгмийн эгэх хариуцлагын дэлхийн түншлэл байгууллага
- НҮБ-ын Ардчиллыг дэмжих сан
- НҮБ-ын Итгэлцлийн сан
- Швейцарын Хөгжлийн Агентлаг
- Японы Олон улсын хамтын ажиллагааны байгууллага (ЖАЙКА)
- Япон Улсын Гадаад харилцааны яам
- Японы Нийгмийн хөгжлийн сан
- Шинэ Зеланд Улсын Элчин сайдын яамны Сан
- FHI360

## ХАМТРАГЧ БАЙГУУЛЛАГУУД

**Яам, агентлаг, харьяа байгууллага**

- Боловсрол, шинжлэх ухааны яам
  - Боловсролын ерөнхий газар
  - Боловсролын судалгааны үндэсний хүрээлэн
- Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам
  - Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар
  - Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар
  - Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засалт, хөгжлийн төв
  - Эрүүл мэндийн яам
  - Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газар
- Хууль зүй, дотоод хэргийн яам
  Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл
- Онцгой байдлын ерөнхий газар

**Их, дээд сургууль**

- АШУҮИС-ийн Сэтгэцийн эрүүл мэндийн тэнхим
- АШУҮИС-ийн цахим сургалтын газар
- МУБИС, МУБИС-ийн Багшийн сургууль
- ШУТИС-ийн Нийгмийн ухааны тэнхим
- Ховд Их сургууль
- Ховд Хөгжил Политехник коллеж

**Нийслэлийн Засаг даргын тамгын газар ба түүний агентлаг, харьяа байгууллагууд**

- Нийслэлийн боловсролын газар
- Нийслэлийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар
- Нийслэлийн эрүүл мэндийн газар
- Нийслэлийн бизнес, инновац, хөгжлийн газар

### Аймгуудын Засаг даргын Тамгын газар ба харьяа байгууллага

- Аймгийн Засаг даргын Тамгын газар
  - Архангай, Говьсүмбэр, Говь-Алтай, Дундговь, Дорнод, Дорноговь, Завхан, Өвөрхангай, Сүхбаатар, Хэнтий, Ховд, Өмнөговь,
- Аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар
- Архангай, Говьсүмбэр, Дорнод, Завхан, Өвөрхангай, Сүхбаатар, Ховд, Дорноговь, Өмнөговь, Хэнтий
- Аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газар
  - Архангай, Говьсүмбэр, Дундговь, Дорнод, Завхан, Өвөрхангай, Сүхбаатар, Ховд
- Аймгийн Насан туршийн боловсролын төв
  - Говьсүмбэр, Завхан, Өвөрхангай, Сүхбаатар, Ховд
- Аймгийн Эрүүл мэндийн газар
- Архангай, Говь-Алтай, Дундговь, Өмнөговь, Дорнод, Сүхбаатар, Хэнтий, Баянхонгор, Өвөрхангай, Төв, Дархан-Уул, Эрдэнэт, Орхон, Говьсүмбэр, Сэлэнгэ, Хөвсгөл, Завхан, Увс, Ховд, Баян-Өлгий, Дорноговь

### Дүүргийн Засаг даргын Тамгын газар, харьяа байгууллага, хороо

- Баянзүрх дүүргийн 9, 23, 27 дугаар хороо
- Баянгол, Баянзүрх, Сонгинохайрхан, Чингэлтэй, Сүхбаатар дүүргийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хэлтэс
- Сонгинохайрхан дүүргийн 2, 7, 8, 9, 10, 11, 28, 40 дүгээр хороо
- Баянзүрх, Сонгинохайрхан, Чингэлтэй дүүргийн боловсролын хэлтэс
- Сүхбаатар дүүргийн 13, 14, 16, 17 дугаар хороо
- Чингэлтэй дүүргийн 2, 9, 10, 11, 12, 13, 14, 18 дугаар хороо

### Сумдын Засаг даргын Тамгын газрууд

- Архангай аймгийн Эрдэнэмандал, Батцэнгэл, Чулуут, Хайрхан сумын Засаг даргын тамгын газар
- Говь-Алтай аймгийн Чандмань сумын Засаг даргын тамгын газар
- Говьсүмбэр аймгийн Чойр, Шивээ-Овоо сумын Засаг даргын тамгын газар
- Дорнод аймгийн Халхгол, Баян-Уул сумын Засаг даргын тамгын газар
- Завхан аймгийн Баянтэс, Тосонцэнгэл, Их- Уул, Тэлмэн, Тэс, Түдэвтэй сум
- Өвөрхангай аймгийн Бат-Өлзий, Богд, Гучин-Ус, Хархорин, Сант, Уянга, Хужирт сумын Засаг Даргын Тамгын Газар
- Сүхбаатар аймгийн Баяндэлгэр, Мөнххаан, Онгон, Эрдэнэцагаан сумын Засаг даргын тамгын газар
- Ховд аймгийн Булган, Буянт, Алтай, Зэрэг, Манхан, Мөст, Үенч сумын Засаг даргын тамгын газар

### Ерөнхий боловсролын сургууль, Насан туршийн боловсролын төв

- Баянзүрх дүүргийн ерөнхий боловсролын 79, 127 дугаар сургууль
- Говьсүмбэр аймгийн Чойр, Шивээ-Овоо сумдын ерөнхий боловсролын сургууль, Насан туршийн боловсролын төв
- Завхан аймгийн Баянтэс, Тосонцэнгэл, Их- Уул, Тэлмэн, Тэс, Түдэвтэй сумдын ерөнхий боловсролын сургууль, Насан туршийн боловсролын төв
- Өвөрхангай аймгийн Арвайхээр, Бат-Өлзий, Богд, Гучин-Ус, Хархорин (II), Хархорин (III), Сант, Уянга (I), Уянга (II) Хужирт сумдын ерөнхий боловсролын сургууль, Насан туршийн боловсролын төв
- Сүхбаатар аймгийн Баяндэлгэр, Мөнххаан, Онгон, Эрдэнэцагаан сумдын ерөнхий боловсролын сургууль, Насан туршийн боловсролын төв
- Сонгинохайрхан дүүргийн ерөнхий боловсролын 65, 67, 105 дугаар сургууль
- Ховд аймгийн 3, 7 ба Буянт, Булган, Алтай, Зэрэг, Манхан, Мөст, Үенч сумдын ерөнхий боловсролын сургууль, Насан туршийн боловсролын төв
- Чингэлтэй дүүргийн ерөнхий боловсролын 37, 49 дүгээр сургууль  
  Политехник коллеж/ Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв
- Ховд, Өвөрхангай, Завхан, Говьсүмбэр аймгийн Политехник коллеж
- Сүхбаатар аймаг, Завхан аймгийн Тосонцэнгэл сумын Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв

### Эмнэлэг

- Бүх лавлагаа шатлалын эмнэлгүүд
- 4 бүсийн оношилгоо эмчилгээний төвүүд
- 21 аймгийн нэгдсэн эмнэлгүүд
- 330 сумын эрүүл мэндийн төвүүд
- Архангай аймгийн Тариат, Эрдэнэмандал сумын эрүүл мэндийн төв
- Говь-Алтай аймгийн Чандмань сумын эрүүл мэндийн төв

### Олон улсын байгууллага

- Азийн Залуучуудын Байгууллага
- Азийн Сан
- Ассист Интернейшнл
- Дэлхийн Зөн Монгол
- Глоб Интернейшнл
- Монгол Улс дахь НҮБ
- НҮБ-ын Хүүхдийн сан
- НҮБ-ийн Шилжилт хөдөлгөөний байгууллага
- FHI360
- Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих холбоо
- Япон улсаас Монгол Улсад суугаа Элчин сайдын яам
- Японы Олон улсын хамтын ажиллагааны байгууллага

### Төрийн бус байгууллага

- Говийн Хөгжил Наран ТББ
- Дохионы хэлний хэлмэрч орчуулагчдын холбоо
- Зориг Сан
- Либерал Эмэгтэйчүүдийн Оюуны Сан
- Монголын ЛГБТ Төв
- Монголын сонсголгүй иргэдийн байгууллагуудын нэгдсэн холбоо
- Монголын урлагийн сэтгэл заслын мэргэжлийн холбоо
- Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим
- Монголын Яаралтай тусламжийн нийгэмлэг
- Нүдэн төв ТББ
- Өмнөговь аймгийн ИНБ-уудын сүлжээ
- Тэргэнцэртэй иргэдийн холбоо
- Хараа хүрэхүй ТББ
- Хэнтийн мэдээ ТББ
- Хотол Чойр ТББ
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхчүүдийн холбоо
- Хөгжлийн шийдэл ТББ
- Хөөрхөн зүрхнүүд ТББ
- Хүний эрхийг хамгаалагч хүүхэд залуусын дуу хоолой ТББ
- Хүйсийн тэгш байдлыг хангах төв
- Хүүхдийн оюуны боловсролыг дэмжих төв
- Цогц хөгжлийн үндэсний төв ТББ

### Хэвлэл мэдээллийн байгууллагууд

- Дөлгөөн Соёмбо ТВ
- Новел Рол ХХК
- Эрэн контент ХХК
- C1 телевиз
- UBS телевиз
- Ийгл Бродкастинг ХХК
- МҮОНРТ



Save the Children

Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, Аризона төв, 4-р давхар
+976-11-329365, +976-11-329371
+976-11-329361

www.savethechildren.mn

Save the Children in Mongolia

Savethechildren.mongolia

Save the Children MN

Save the Children in Mongolia

© Гэрэл зургуудын эрхийг Хүүхдийг Ивээх Сан эзэмшинэ.